

ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН СУРГАЛТ-ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ ЦОГЦОЛБОРТ АМЬДАРЧ БУЙ ХҮҮХДҮҮДЭД ГАР УРЛАЛЫН СУРГАЛТААР ДАМЖУУЛАН СЭТГЭЛ ЗҮЙД НӨЛӨӨЛӨХ НЬ

*Ж. Алтанчимэг
Магистр оюутан*

Нийслэлийн хүүхэд, залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолбор

altchimegj@gmail.com

*Т. Оюунбилэг
Доктор (Ph. D.)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Нийгэм, хүмүүнлэгийн сургууль*

oюнbileg@must.edu.mn

***Хураангуй:** Хүүхэд залуучуудын сургалт-хүмүүжлийн тусгай цогцолборт амьдарч байгаа нийгэм, сэтгэл зүйн хувьд өвөрмөц онцлогтой өсвөр насны хүүхдүүдэд гар урлалаар дамжуулан сэтгэл зүйд нь нөлөөлөх зорилгоор лаа, саван, лааны суурь, давсан урлал зэрэг сургалт зохион байгуулж, хүүхдүүдээс ганцаарчилсан ярилцлагын аргаар үр дүнг үнэлэхийг зорилоо. Үйлчлүүлэгчийн нийгэм, сэтгэл зүйн байдлын үр нөлөөг үнэлэхэд бие даан суралцах, өөрийгөө хөгжүүлэх чадвар сайжирсан (25.9 хувь), өөртэй итгэх итгэл нэмэгдсэн (14.8 хувь), сурлага сайжирсан (14.8 хувь), сэтгэл гутрал нь багасаж байгаа (11.1 хувь), анхаарлаа төвлөрөлт нэмэгдэж байгаа (11.1 хувь), өөрийн гэсэн орлоготой болж байгаа (7.4 хувь), өөртэй анхаарал тавьдаг болсон (7.4 хувь) зэрэг үр нөлөө гарсан байна. **Түдхүүр үг:** Гар урлалын сургалт, нийгэм, сэтгэл зүйн байдал, урлагийн засал, үр нөлөө*

УДИРТГАЛ

Манай улсын хүн амын тодорхой хувийг 18 хүртэлх насны хүүхдүүд эзэлдэг бөгөөд өнөөдрийн байдлаар хүүхдийн төрөлжсөн асрамж, халамжийн 42 газарт 1151 хүүхэд амьдарч байна.

Хүүхдийн төв нь нийслэлийн хэмжээнд эцэг, эхийн хараа хяналтаас гарсан, гэр

оронгүй, хүнд нөхцөлд амьдарч байгаа хагас болон бүтэн өнчин 4-17 насны хүүхдүүдийг Нийслэлийн Цагдаагийн газрын Хүүхэд хамгаалал, хаяг тогтоох төв болон дүүргүүдийн Засаг даргын захирамжаар хүлээн авч, 18 нас хүртэл нь байнга байрлуулан, сурч боловсрох нөхцөл боломжоор

хангаж, халамжлан хүмүүжүүлж, нийгэмшүүлэх 24 цагийн үйл ажиллагаатай төрийн үйлчилгээний байгууллага юм [1]. Одоогийн байдлаар 4-17 насны нийт 75 хүүхдийг сурган хүмүүжүүлж, халамжлан өсгөж байна. Төвд ирж буй хүүхдүүдийн ихэнх нь бичиг үсэг мэдэхгүй, сургууль завсардсан, амьдрах арга барил эзэмшээгүй, эмзэг бүлгийн хүүхдүүд байдаг [2].

Сүүлийн жилүүдэд эцэг эхтэй хүүхдүүд асрамжийн газарт ирэх нь нэмэгдэж байгаа бөгөөд ихэвчлэн эцэг эх нь архины хамааралтай. Мөн хүүхдээ асрамжийн төвд үлдээгээд дахин гэр бүл зохиочихдог хариуцлагагүй үндсэн хуулинд заасан эрх үүргээ биелүүлдэггүй эцэг, эх олширч үл хайхрах хүчирхийлэлд хүүхдүүд өртөж, асрамж халамжийн төвд ихээр ирэх болсон. Эдгээр хүүхдүүд сэтгэл зүйн хувьд тогтворгүй, сэтгэл гутрал, стресс, депресс, сэтгэл түгшүүр, сэтгэл зүйн бэрхшээлтэй тулгарч байдаг. Иймд тухайн хүүхдийн сэтгэл зүйг засах, ойлгох, хөдөлмөрт сургадаг давуу талтай гар урлалын сургалтыг зохион байгуулах хэрэгцээ, шаардлагатай байна.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Судлагдсан байдлын тойм.

Тус төвд амьдарч, сурч, хүмүүжиж буй өсвөр насныхны өнөөгийн нөхцөл байдлыг тус төвийн бүлгийн нийгмийн ажилтан, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн ажлын тайланд үндэслэн дараах байдлаар

жил бүр тайлагнадаг бөгөөд энэхүү тайланд үндэслэн өнөөгийн байдлыг тодорхойлж байна.

Төвийн хүүхдүүдийн нас, нийгэм, сэтгэл зүйн онцлог: Тус төвд 04-23 насны хүүхэд, залуучууд амьдардаг. Ихэвчлэн сэтгэл зүйн хувьд тогтворгүй, сэтгэл гутралтай стресс, депресс, сэтгэл түгшүүр, сэтгэл зүйн бэрхшээлтэй тулгарч байдаг. Эцэх эхтэй хүүхдүүд нь бүтэн өнчин хүүхдүүдээс илүүтэйгээр гэр бүлээ санах, санаа зовинох, сэтгэлээр унах, гадуур сэлгүүцэж тэнэх зэрэг үйлдэд гаргах нь их байдаг [2].

Төвийн хүүхдүүдийн гэр бүл, нийгмийн байдал: Одоогийн байдлаар 75 хүүхдийг сурган хүмүүжүүлж, халамжлан өсгөж байна. Үүнээс:

- Бүтэн өнчин -20.0 хувь буюу 15 хүүхэд
- Хагас өнчин-30.0 хувь буюу 23 хүүхэд
- Гэр бүл салсан-50.0 хувь буюу 37 хүүхэд амьдарч байна.

Ихэнх хүүхдүүдийн хувьд эцэг эхтэй боловч ажилгүйдэл, ядуурал, түүнээс улбаатай архидалт, мансуурал зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд, эцэг, эх, асран хамгаалагчдаас үр хүүхдэдээ тавих хараа хяналт дутсанаас хүүхэд сургууль завсардах, элдэв сөрөг нөлөөнд автах, улмаар гэмт хэрэг үйлдэх, гэмт халдлагад өртөх явдал их байдаг. Хэдийгээр эцэг эх нь үл хайхардаг архи, мансууруулах бодис хэрэглэдэг ч эцэх эхтэй

хүүхдүүд илүү их сэтэгл санааны хувьд тогтворгүй ар гэртээ санаа зовинох нь их ажиглагддаг. Хүүхдээ асрамж халамжийн төвд шилжүүлсэн эцэх эх тэр болгон засарч сайжран хүүхдүүдээ авах нь бага байдаг.

Төвд ирж буй хүүхдүүдийн ихэнх нь бичиг үсэг мэдэхгүй, сургууль завсардсан, амьдрах арга барил, эзэмшээгүй, эмзэг бүлгийн хүүхдүүд байдаг учир хүүхдийн төв нь дотроо албан бус сургалтаар боловсролэзэмшүүлэх, хоцрогдол арилгах сургалтыг зохион байгуулж, тойргийн Ерөнхий боловсролын сургуулиудад суралцуулдаг.

Нийгмийн харилцаа, танин мэдэхүйн байдал: Тус төвийн хүүхдүүдийн 95.0 хувь нь ерөнхий боловсролын Амгалан цогцолбор, 92, 55-р сургуулиудад, 32-р цэцэрлэг болон бусад цэцэрлэгт суралцаж чөлөөт цагаараа гар урлал, спортын дугуйлан секцүүдэд явж авьяас чадвараа хөгжүүлж байна [2].

Онолын тайлбарлал. Эрдэмтэд урлагийн сэтгэл засал нь хүүхдүүдэд илүү тохиромжтой гэж үздэг. Учир нь тэд төрөлхийн үгэн болон үгэн бус хэлбэрээр юу мэддэг, юу мэдэрч байгаагаа маш сайн илэрхийлж чадна. Мөн урлагийн засалчид хүүхдэд аюулгүй буюу эмзэглүүлэхгүйгээр тэдний дуртай хэрэгслийг ашиглан ажиллаж хүүхдийн амьдралд үлдсэн хар толбыг арилгах, нөхөн сэргээх, асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг гэж Эмма Миллс,

Степание Келлингтон нар үздэг. Хүүхдүүд урлагийн хэрэгсэлтэй ажиллахдаа дуртай байдаг бөгөөд энэ нь эмчлэх, эдгээх явцад эерэг нөлөө үзүүлдэг байна. Тухайлбал Велтман, Браун нар хүүхэд зураг зурж байхдаа юу бодож, мэдэрч байгаагаа заавал ярих шаардлагагүй гэж үзсэн. Мөн Пелед, Девис нар хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд “Чи дуугүй бай”, “Юу болсон талаар бүү ярь”, “Өөрт төрсөн мэдрэмжээ битгий илэрхийл”, “Битгий асуулт асуу”, “Хэнд ч бүү хэл” гэх мэт үгийг байнга сонсдог гэж үзжээ. Тийм учраас хүчирхийлэлд амьдарч байгаа хүүхдүүд өөрт төрж буй мэдрэмж, сэтгэл хөдлөлөө үгээр илэрхийлэхэд бэрхшээлтэй байдаг. Иймээс тэднийг өөр аргаар илэрхийлэхэд урлагийн сэтгэл засал тохиромжтой. Ихэнх тохиолдолд тэдний эцэг эх өөрсдөө хүүхэд байхдаа хүчирхийлэлтэй орчинд төрж, өсөж, өөрийгөө илэрхийлэх ур чадвар эзэмшээгүй байдаг [3].

Урлагийн засал нь хөдөлмөрийн засал шиг шинэ зүйл үйлдвэрлэн бүтээх, орлогоо нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжид онцгой анхаарахын зэрэгцээ үйлчлүүлэгч өөрийн сонирхлоос хамаарч материал бэлтгэх, боловсруулах, зураг зурахийн аль нэгийг нь сонгож хийх замаар сэтгэл санааны хувьд тайвшрах, идэвхжих, амсхийх боломжийг олгодог [4].

Нөгөө талаас үйлчлүүлэгчийн өөрийн үнэлэмж, чармайлтын түвшин, бие хүний онцлог шинжийг харгалзан уран бүтээл хийлгэх бөгөөд тодорхой нөхцөл байдалд үйлчлүүлэгчийг ажиглан судалж байдаг.

Урлагийн заслын хүрээнд уран сайхны хавсарга шинжтэй модон сийлбэр, хээ цохих, шавар урлал, төөнүүр, зураг зурах, шигтгэмэл, үслэг эдлэлийн урлал, нэхмэл гэх мэт хичээлүүдийг багтаадаг.

Урлагийн заслын хичээлийг 2 арга замаар хөтлөн явуулдаг. Нэгдүгээрт, Тодорхой сэдвээр зураг зурж болох материал хэрэгслийг бэлтгэж хэрэглүүлэх. Тэгэхдээ тодорхой сэдвийн хүрээн дэхь өөрийн ахуйг илэрхийлж буй байдал, тухайлбал цэцэг зурж буй байдал, түүний өвөрмөц хэлбэр нь сэтгэл зүйн тусгал болж буй сэтгэл хөдлөл, мэдрэмж, хүрээлэн буй орчинд хандах хандлагын мөн чанартай шууд холбоотой байдгийг харж чадна. Тухайлбал проектив тестүүдийг ашиглан үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдалд оношлол хийж болно. Урлагийн заслын нөлөөллийг энэ тохиолдолд ойлгохын зэрэгцээ оношлолын хангалттай материалыг цуглуулж болно.

Хоёрдугаарт, Тодорхой бүтэц, зохион байгуулалтгүй хичээл. Үйлчлүүлэгч сэдэв, материал, хэрэглэгдэхүүнээ өөрөө сонгодог. Хичээлийн төгсгөлд сэдвүүд болон хийж гүйцэтгэсэн

байдалтай холбоотой хэлэлцүүлэг хийдэг. Дасал болоогүй хичээлийн өмнө үйлчлүүлэгчид бий болсон айдас, шийдэмгий бус байдал, ичиж зовсон байдлыг даван туулах явдал тохиолддог. Нэгдүгээр үе шатанд урлагийн заслын зорилго нь үйлчлүүлэгч урлагийн заслын явцад биеэ барьсан байдлаа даван туулж, харилцаанд ороход тус дөхөм болдог.

Урлагийн заслын үүрэг нь тодорхой нөхцөл байдлаас хамаарч нарийн төвөгтэй байдаг. Үйлчлүүлэгчид хичээлийн бүх төрлийг зайлшгүй сурч эзэмшиж, хичээлийг гүйцэтгэсэн ч хэлэлцүүлэгийн явцад огт ярихгүй байж болно.

Урлагийн заслын хамгийн чухал хэсэг нь үйлчлүүлэгчтэй харилцаагаа сайжруулах явдал байдаг. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдал, хувийн онцлог, мэдлэг, оюун ухааны түвшин гэх мэт олон зүйлийг судлан тодорхойлох ёстой. Хичээлийн явцад бүлгийн гишүүдийн харилцааны төлөвшил, уран бүтээлийн туршлага бий болж буй байдал зэргийг ажиглах бүрэн бололцоотой учраас нийгмийн ажилтан үйлчлүүлэгч хоёрын хоорондын харилцаа холбоо алгуур бүрэлдэн тогтдог. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчдийг хамтран ажиллах, асуудлаа нийтэд ярих, өөрийгөө бүлгийн хэн нэгэн гишүүний түвшинд аваачих, нөхөрлөлийг бий болгох, дарангуйлахгүй байх байдлыг бий

болгох нөхцлийг бүрдүүлэх ёстой. Мөн үйлчлүүлэгчид гоо зүйн дадал, чадварыг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулдаг.

Урлагийн заслын кабинетын үүрэг нь олон төрлийн эмчилгээний явцаас хамаарч өөрчлөгдөж байдаг. Хичээлийн эхний хэсэгт кабинет нь үйлчлүүлэгчийг харилцаанд оруулах, дасан зохицуулах зорилгыг хангахуйц заслын орчинд хурдан, сайн зохицоход туслахаар байна. Урлагийн заслын явцад өөрийгөө илэрхийлэх, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадварууд бий болж хөгждөг бөгөөд хүчирхийлэх байдал үгүй болдог. “Би бусдаас дутах юмгүй” гэсэн өөрийн үнэлэмж дээшилдэг. Энэ үед л заслын нөлөөлөл эрчимжих зам нээгддэг.

Урлагийн заслын явцад үйлчлүүлэгчийн урлан бүтээх бололцоог нээх, бие даан уран бүтээлийн янз бүрийн төрлүүдээр сонирхон хичээллэх, заслын явцад ямар ямар дадал чадвар бий болсон эсэх талаар баримтыг цуглуулна [4].

Гар урлалын сургалтын үр нөлөөг нэгд, үйлчлүүлэгчийн байр байдлыг үнэлэх, хоёрт, кабинетад хичээллэсэн бодит байдал, хичээлийн оролцоо, гуравд, өөрийн бүтээлийн үр дүнд сонирхол

нэмэгдэх байдал, дөрөвт, бие даан хичээлийг гүйцэтгэх байдал зэрэг 4 үндсэн шалгуураар үнэлэх боломжтойг онол, арга зүйн хувьд тодорхойлсон.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Хүүхэд залуучуудын сургалт-хүмүүжлийн тусгай цогцолборт амьдарч байгаа нийгэм, сэтгэл зүйн хувьд өвөрмөц онцлогтой 14-17 өсвөр насны 10 охидод гар урлалын сургалтаар дамжуулан сэтгэл зүй нь тайван байдлаа хадгалж сургах, нөлөөлөх зорилгоор 2024 оны 12 сарын 28-аас 2025 оны 03 сарын 28 хүртэлх хугацаанд 7 хоног тутамд 3 удаа, 2 цагийн хугацаанд лаа, саван, лааны суурь, давсан урлал зэрэг сургалт зохион байгуулсан.

Урлагын заслын үйл явц, үр дүнг үнэлэх 4 үндсэн шалгуурын хүрээнд хүүхдүүдэд гарсан үр нөлөө, өөрчлөлтийг ганцаарчилсан ярилцлага, кейс файлын нэгдсэн дүгнэлтийг харьцуулах аргаар үнэлсэн.

1. Үйлчлүүлэгчийн байр байдлыг үнэлэх. Энэ шалгуурын хүрээнд тус төвийн сурагчдын кейс файлыг ашиглаж, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн гаргасан нэгдсэн дүгнэлтийг харьцуулан үр нөлөөг үнэлэв.

Хүснэгт 1. Сургалтад хамрагдсан сурагчдын нийгэм, сэтгэл зүйн төлөв байдал

№	Сургалтын өмнөх нийгэм, сэтгэл зүйн ерөнхий дүгнэлт	Сургалтын дараах нийгэм, сэтгэл зүйн ерөнхий дүгнэлт
1	Сэтгэлзүйн хувьд тогтворгүй, бие даан суралцах чадвар, өөртэй итгэх итгэл сул, сэтгэл гутралтай.	Бие даан суралцах чадвар, өөртэй итгэх итгэл нэмэгдсэн. Сэтгэл гутралын шинж тэмдэг багассан. Хичээлдээ анхааралтай сууж, сургалтын чанар сайжирсан. Шалгалтын дун 56 хувь болж өссөн.
2	Ааш зан тогтворгүй, түргэн ууртай, хичээлд явах дургүй, харилцааны зөрчил гаргадаг.	Уураа барьж сурч байгаа, хичээлдээ тогтмол явж байна. Насан туршийн боловсролын төвөөс ерөнхий боловсролын сургуульд амжилтай шалгалт өгч дэвшин суралцаж байна. Ааш зан тогтворжиж байна.
3	Өөрийгөө илэрхийлэх чадвар сул, өөртэй итгэх итгэл багатай, хэл ярианы бага зэргийн бэрхшээлтэй, өөрийгөө голдог.	Түргэн хэллэг цээжилж хэл ярианы чадвараа сайжруулж байгаа. Сэтгэлээр унах нь багасаж хувцсаа цэвэрхэн өмсөж, өөртэй анхаарал тавьдаг болсон. Гэрийн даалгавраа тогтмол хийж сургалтын чанарт ахиц гарч байна.
4	Үг дуу цөөнтэй, өөрийгөө илэрхийлэх чадвар сул, ичимхий, даруу төлөв	Өөртэй итгэлтэй болсон. Сурлага сайжирч, өөртэй анхаарал тавьдаг болсон.
5	Сэргэлэн цовоо, бусдыг манлайлах чадвартай, хэл яриа сайтай, хурдан сурдаг, сурлага сайн.	Өөрөө бие дааж нэхмэл сурсан. Цүнх болон аяганы суурь нэхэж, интернетээр зардаг. Өөрийн гэсэн орлоготой болж байгаа.
6	Сэтгэлээр ундаг, үргэлжийн санаа зовдог. Ганцаардмал, тогтвор суурьшил багатай.	Анхаарлаа төвлөрүүлж удаан суудаг. Бие дааж зураг зурдаг. Гэр бүлийн өдөрлөгөөр ээждээ зориулж лаа, саван, зураг зурж өгсөн. Найзтай болж байгаа, тогтвортой сууж хичээлээ хийдэг болсон.
7	Үг дуу цөөнтэй, сэтгэлээр унамтгай мартамхай, бие дааж сурах чадвар сул, хичээлд явах дургүй.	Сургалтанд тогтмол хамрагдаж чаддаггүй. Сэтгэл санаа нь тогтвортой бус, хичээл завсардаж, амралтын өдрөөр чөлөөгөөр явдаг.
8	Бие муутай, сэтгэл гутралтай, үг дуу цөөнтэй, өөрийгөө илэрхийлэх чадвар сул.	Сэтгэл гутрал нь багасаж байгаа, тогтмол сургалтад сууж чаддаггүй.
9	Түрэмгий, ууртай, зөрүүд, анхаарал султай.	Бусдтай нийцтэй байж сургалтандаа сууж байгаа, анхаарал төвлөрүүлж сурч байна.
10	Спорт, сурлага сайн. Бусдыг манлайлагч, сэргэлэн цовоо.	Бусдаас хурдан сурдаг. Өнгө, хэлбэрийн гоёмсог байдлыг эрхэмлэдэг, хийсэн бүтээл нь хурдан зарагддаг. Интернетээр өөрийн бүтээлээ зардаг.

Үйлчлүүлэгчийн нийгэм, сэтгэл зүйн байдлын 27 үр нөлөөг илэрхийлсэн тохиолдол илэрсэн бөгөөд давтагдсан тоогоор харьцуулан үнэлэхэд

- Бие даан суралцах, өөрийгөө хөгжүүлэх чадвар сайжирсан-7 буюу (25.9 хувь)
- Өөртэй итгэх итгэл нэмэгдсэн-4 буюу (14.8 хувь)
- Сурлага сайжирсан-4 буюу (14.8 хувь)
- Сэтгэл гутрал нь багасаж

байгаа-3 буюу (11.1 хувь)

- Анхаарлаа төвлөрөлт нэмэгдэж байгаа-3 буюу (11.1 хувь)
- Өөрийн гэсэн орлоготой болж байгаа-2 буюу (7.4 хувь)
- Өөртэй анхаарал тавьдаг болсон.-2 буюу (7.4 хувь) зэрэг үр нөлөө гарсан байна.
- Уураа барьж, ааш зан тогтворжиж байгаа-2 буюу (7.4 хувь) цур нөлөөг судлан тодорхойлов.

Кейс 1.

. . . Лаа хийх сургалтанд хамрагдсанаар бүтээл туурвих урам зоригтой болж өөрийн хийсэн лаануудаа цаашид өөрөө олшруулан борлуулах бэлтгэх зэргээр ашиглаж эхэлсэн бөгөөд бусад урлагийн төрлүүдэд сонирхол төрүүлж, нэхмэл сүлжмэл хийх гар урлалын бүтээл хийх зэрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцох болсноор бүтээлч чадвараа хөгжүүлж байна. Би гар урлал хийх явцдаа хичээл сургалтандаа сайжирч, анхаарал төвлөрөлт нь нэмэгдсэн. Цаашдаа улам бүр хичээх болно. . .

Сургалтын бүлгийн гишүүний сэтгэлдэл

2. Кабинетад хичээллэсэн бодит байдал, хичээлийн оролцоо. Нийт 36 удаагийн гар урлалын хичээлд 72 цагийн сургалтад 10 охин хамрагдсан. Охидын гар урлалын бүлгийн идэвх оролцоо 90.0 хувьтай байна. Тэдгээрийн 80.0 хувь нь сургалтын агуулга хангалттай, ойлгомжтой байсан, 60.0 хувь нь цаашид ийм төрлийн сургалт дахин оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлж байна.

оролцогч хэрэглэгдсэн материалын чанар, төрлийн сонголтыг нэмэгдүүлэх хүсэлтэй байгааг илэрхийлж, тус төвийн гар урлалын танхимын тохижилтод анхаарах болсон.

Кейс 2.

. . . Эхэндээ зүгээр л сонирхож суусан ч лаа хийхэд их гоё мэдрэмж төрсөн. Би хийсэн лаагаа найздаа

бэлэглэсэн тэгээд өөрөө улам гоё болгох гэж гэж хичээгээд дараа нь өөр бүтээл хийж үзмээр санагдсан. Одоо би сүлжмэл нэхэж сурч байгаа. Лааны сургалтад хамрагдсанаар би өөртэй итгэх итгэл нэмэгдсэн. Шинэ зүйлийг сурахдаа илүү идэвхтэй болсон. Хичээл сонирхолтой, багш ойлгомжтой заадаг болохоор сурахад урам зориг өгдөг. . .

Сургалтын бүлгийн гишүүний сэтгэлдэл

3. Өөрийн бүтээлийн үр дүнд сонирхол нэмэгдэх байдал. БЗД-ийн 23 хорооны “Улиастай” захын гар урлалын лангуун дээр борлуулж, нийт 2.350.000 төгрөгний орлого олж байна. Тус орлогоосоо сургалтын хэрэглэгдэхүүний мөнгөө хасч, үлдсэн мөнгөөрөө, ЭЕШ-ын ном, гарын авлага, хэрэгцээт хувцас, гар урлал, маникюрын хэрэгсэл худалдан авч байна. Зарим

4. Бие даан хичээлийг гүйцэтгэх байдал. Эсгий урлал хийх материал хэрэглэгдэхүүн, бүжгийн болон спортын дугайлангийн хувцас зэргийг багшийг дагалдан явж худалдан авалтууд хийсэн нь нийгэм, эдийн засгийн амьдралд дасан зохицох, хөдөлмөрийн үр шимээ хүртэж амьдрахын практик дадлыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна. Цаашдаа хуримтлал бий болгох зорилготой суралцаж

байна. Мөн “Жамъяанмядаг 2025” шилдэг нэрийн шагналт бүтээгдэхүүний шагнал хүртсэн байна. Мөн БЗД-ийн жижиг дунд

үйлдвэрийг дэмжих сангаас зохион байгуулсан 17 болон 19, 24 дүгээр хорооны үзэсгэлэн худалдаануудад 4 удаа амжилттай оролцсон.

Зураг 1. Гар урлалын сургалтын өрөө, бүтээл, шагналууд



ДҮГНЭЛТ

Нийт 36 удаагийн гар урлалын хичээлд 72 цагийн сургалтад 10 охин хамрагдсан. Охидын гар урлалын бүлгийн идэвх оролцоо 90.0 хувьтай байна. Тэдгээрийн 80.0 хувь нь сургалтын агуулга хангалттай, ойлгомжтой байсан гэж үнэлж байна. Үйлчлүүлэгчийн нийгэм, сэтгэл зүйн байдлын үр нөлөөг үнэлэхэд бие даан суралцах, өөрийгөө хөгжүүлэх чадвар сайжирсан (25.9 хувь), өөртэй итгэх итгэл нэмэгдсэн (14.8 хувь), сурлага сайжирсан (14.8 хувь), сэтгэл гутрал нь багасаж байгаа (11.1 хувь), анхаарлаа төвлөрөлт нэмэгдэж байгаа (11.1 хувь), өөрийн гэсэн орлоготой болж байгаа (7.4 хувь),

өөртэй анхаарал тавьдаг болсон (7.4 хувь) зэрэг үр нөлөө гарсан байна.

Мөн хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн 60.0 хувь нь энэхүү сургалтыг үргэлжлүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлж байсан нь хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага өндөр байгааг харуулж байна.

НОМ ЗҮЙ

- [1] Сургалт-хүмүүжлийн тусгай цогцолборын веб сайт, Улаанбаатар, 2025
- [2] Сургалт-хүмүүжлийн тусгай цогцолборын хүүхдийн гэр бүл, нийгмийн байдлын судалгаа. 2025
- [3] НҮБ. ХАС. Хүчирхийллийн хохирогчид нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй. 2019
- [4] Т.Оюунбилэг. Сэтгэл заслын 48 аргууд. Улаанбаатар, 2022